


ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН ЦАХИМ СИСТЕМ /WWW.URBAN.GOV.MN/-ИЙН ТУХАЙ

Хот байгуулалтын кадастр гэж нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдал, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны чанарын тухай байр зүйн зураглал, мэдээллийн нэгдмэл санг хэлнэ. Хот байгуулалтын кадастр нь хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл бүхий улсын сан юм.


Тус газраас “Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/”-ийг Газрын даргын 2020 оны А/137 дугаар тушаалаар 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн.




Хот байгуулалтын кадастрын цахим систем

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ийн олон нийтэд зориулсан НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ цэснээс иргэн, хуулийн этгээд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран барилга байгууламж, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, тохижилт, ногоон байгууламж, орон зайд суурилсан өгөгдөл мэдээллүүдийг харахаас гадна хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөг давхцуулан харах боломжтой.

Хот байгуулалтын кадастрын цахим систем [/www.urban.gov.mn/](http://www.urban.gov.mn)-ээс харах боломжтой мэдээлэл



Хот байгуулалтын кадастрын цахим систем [/www.urban.gov.mn/](http://www.urban.gov.mn/)-ээр барилга барих хүсэлтээ гаргахаас эхлээд архитектур төлөвлөлтийн даалгавар, барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах зэрэг шат дараалсан үйл ажиллагааг цахимжуулахаас гадна инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг цахимжуулж иргэн, хуулийн этгээд шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон.



Зураг. Хот байгуулалтын кадастрын цахим системийн үйл ажиллагааны схем

Мөн улсын хэмжээнд **500,000** гаруй барилгын мэдээллийн санг үүсгэн газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлснээр гурав болон дөрвөн /3d, 4d/ хэмжээст кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах суурь бүрдэх юм.

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН ЦАХИМ СИСТЕМ [/WWW.URBAN.GOV.MN/](http://WWW.URBAN.GOV.MN/)-ЭЭС ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хот байгуулалтын кадастрын цахим систем /www.urban.gov.mn/-ээс та дараах үйлчилгээг авах боломжтой.

- 1** Барилга байгууламж шинээр барих АТД олгох
- 2** Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах даалгавар олгох
- 3** Барилга байгууламжийн гадна тохижилтын зураг төсөл боловсруулах даалгавар олгох
- 4** Барилга байгууламжийг өргөтгөн шинэчлэх зураг төсөл боловсруулах даалгавар олгох
- 5** Барилга байгууламжийн их засварын зураг төсөл боловсруулах даалгавар олгох
- 6** Барилгын загвар зураг батлах
- 7** Тохижилтын загвар зураг батлах
- 8** Инженерийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх
- 9** Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ шинээр олгох
- 10** Барилгын ажлын зөвшөөрлийн хугацаа сунгуулах
- 11** Барилгын ажлын зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулах
- 12** Барилга байгууламжийг буулгах ажлын зөвшөөрөл олгох
- 13** Инженерийн дэд бүтэц, шугам сүлжээний ажлын зөвшөөрөл олгох
- 14** Тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх /барилга/
- 15** Тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх /шугам сүлжээ/
- 16** Гүйцэтгэлийн байрзүйн зургийг мэдээллийн санд хүлээн авах
- 17** Барилга ашиглалтанд оруулах комиссын дүгнэлт олгох